

Яг одоо бүртгүүлээрэй

www.apnic.net/apply

Өөрийн IP хаяг болон AS дугаар бүхий сүлжээгээ бий болгоход тань APNIC тусална. Та өөрийн сүлжээний хамрах хүрээ, тасралтгүй ажиллагаа, найдвартай байдлыг илүүтэйгээр хянах боломжтой болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАХ

ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТӨЛБӨР ХИЙХ

БҮРТГЭЖ ДУУСГАХ

Өргөдөл гарган, APNIC гишүүн болох үйл явц нийтдээ ажлын 10 хоногт багтана.



APNIC нь Ази Номхон далайн бүс нутгийн интернет бүртгэлийн байгууллага бөгөөд бүс нутаг дахь IP хаяг, AS дугааруудыг зохицуулж, түгээх ажлыг хариуцдаг.

Бидэнтэй утас, скайп, болон шууд чатаар 09:00-21:00 (UTC+10) цагуудад Даваа-Баасан гаригуудад холбогдох боломжтой

Утас	+61 7 3858 3188
Скайп	apnic-helpdesk
Суурин утас (VoIP)	helpdesk@voip.apnic.net
Чат	www.apnic.net/helpdesk
Е-мэйл	helpdesk@apnic.net




Англи, Индонезийн Бахас, Малайзын Бахас, Малай, Сингал, Тамил, Телугу, Хятадын Кантон, Хятадын Мандарин, Хинди, Филиппин (Тагалог), Япон хэл дээр утсаар холбогдон туслалцаа авах боломжтой.



Та өөрийн гэсэн
**ИНТЕРНЕТ
НӨӨЦТЭЙГӨӨР**
интернэттэй
холбогд

APNIC-н гишүүн болсноор танай байгууллага өөрийн гэсэн IP хаягийн багц болон AS дугаартай болох болно.



www.apnic.net

Ази Номхон далайн Сүлжээний Мэдээллийн Төв

APNIC нь өөрийн хураамж төлбөрүүдээ танд мэдэгдэлгүйгээр өөрчлөхөртэй

2017 оны 12-р сарын 1-н өдөр хэвлэв

Манай гишүүн болсноор



Гишүүнчлэлийн давуу талууд



APNIC –ийн гишүүнчлэлийн хураамж

Өөрөө хянах боломжтой бай

Өөрийн гэсэн IP хаягтай болсноор интернет сүлжээнд ажиллагаа тань илүү уян хатан (оператор хооронд шилжих гэх мэт) болох ба тогтвортой ажиллагаа нь сайжирна.

Мэдээлэлтэй бай

Өндөр зэрэглэлийн технологийн мэргэжилтнүүдээс суралцах боломжтой

Оролцоотой бай

Мэргэжил нэгтнүүдтэйгээ харилцан тэргүүн туршлагаа солилцох, хамтран ажиллах

Тусдаа IP хаяг ашигладаг болсноор интернет үйлчилгээ үзүүлдэг ISP компаниа солих, peering тохиргоогоо чөлөөтэй сонгох боломжтой

Сүлжээний хаяглалтаа шинэчлэхэд гардаг зардлаа багасгах

Зөвхөн хэрэглэгчид хандах боломжтой системд нэвтрэх эрхтэй болсноор өөрийн интернет хаягаа хянах болон өндөр нууцлалтай Routing тохиргоо хийх

APNIC сургалтад хөнгөлөлттэй үнээр хамрагдах эсвэл үнэгүй зайн сургалтад хамрагдсанаар интернет технологийн талаарх мэдлэгээ өргөжүүлэх. Тухайлбал, сүлжээний аюулгүй байдал, IPv6 ,DNS сервер, BGP тохиргоо гэх мэт

Техникийн тусламж үйлчилгээнд хамрагдан Сүлжээ ашиглалтын талаар туршлагатай мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах

Ази Номхон далайн бүс дэх IP хаяглалтын нөөцийг хэрхэн удирдах, хэрэглээг хэрхэн хангах талаар саналаа хэлж, бодлого боловсруулах ажиллагаанд оролцох

Шинэ гишүүний хувьд та нэг удаагийн хураамж болох AUD 500.00, мөн гишүүнчлэлийн жилийн хураамжаа төлнө. Гишүүнчлэлээ 12 сар тутамд шинэчлэх ёстой бөгөөд гишүүнчлэл сунгах хураамж нь таны нийт хэдэн IP хаягтайгаас шалтгаална. Доорх хэдэн жишээг дурдвал:

ШИНЭ ГИШҮҮНИЙ ТӨЛБӨР ХУРААМЖУУД - Жишээ

IPv4	IPv6	ASN	APNIC-ийн гишүүнчлэлийн хураамж (шинээр элссэний хураамж төлбөрийг оролцуулан, австрали доллараар)
/24 (256 хаяг)	/48	1	1,050 (+500) = 1,550
/23 (512 хаяг)	/48	1	1,373 (+500) = 1,873
/22 (1,024 хаяг)	/32	1	1,796 (+500) = 2,296
/21 (2,048 хаяг)	/32	1	2,350 (+500) = 2,850

Үйлчилгээний сунгалтын төлбөрөө www.apnic.net/fees руу орж тооцож болно

IP хаяг гэж юу вэ?

Интернет протокол хаяг буюу IP хаяг нь тухайн төхөөрөмжийг интернет ертөнцтэй холбоход зориулагдан оноосон, хоорондоо үл давхцах хаяглалт юм.

2 төрлийн IP хаяг байдаг ба эдгээр нь 32 бит урттай IPv4 болон 128 бит урттай IPv6 хаяг байна.

AS дугаар гэж юу вэ?

Тухайн бие даасан сүлжээний системд олгогдох, үл давхцах дугаар юм.

Тусгаар систем буюу Autonomous System гэдэг нь нэг буюу хэд хэдэн сүлжээний операторуудын IP хаягийн багцууд холбогдсон IP сүлжээний нэгдэл бөгөөд тодорхой дүрэм бүхий, сүлжээний замчлал (Routing Policy) ашигладаг.

Танд олгогдох IP хаягийн урт нь танай байгууллагад дараагийн 12 сарын хугацаанд шаардагдах хэрэгцээнд үндэслэнэ. Буурай хөгжилтэй орон дахь байгууллагууд бүх төрлийн хураамжаас 50% чөлөөлөгдөнө.

APNIC-н гишүүд нь Интернет үйлчилгээ үзүүлэгчид, Клоуд үйлчилгээ үзүүлэгчид, Харилцаа холбооны оператор компаниуд, Санхүүгийн болон төрийн байгууллагууд, их дээд сургуулиуд гэх мэт интернет холболтын өргөн хэрэгцээтэй байгууллагууд байдаг.

